

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НХТЖҮЧ 3.1.1, 3.2.1 НЗДҮАХ 2.4.1 Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх

2024 онд 713 /давхардаагүй тоогоор/ иргэнийг хүлээн авч, анхан шатны ярилцлага хийж, байрлах хүсэлтийг шийдвэрлэж ажилласан байна.

713 үйлчлүүлэгч иргэний ерөнхий мэдээллийг жагсаалтаар гаргаж, судалгаа хийхэд 452 иргэн анх удаа бүртгэгдсэн, 261 иргэн давтан үйлчилгээ авсан нь харагдаж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээ авсан иргэдийн тоо 75%-иар нэмэгдсэн нь цагдаагийн байгууллагын илрүүлэг арга хэмжээг 53 удаа зохион байгуулсантай холбоотой юм.

2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН СТАТИСТИК

№	Статистикын нэршил	Тоо	Тайлбар
1	Хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн иргэд	713	Өөрийн хүсэлтээр болон цагдаагийн байгууллагаар дамжин төвд хүсэлт авахаар ирсэн иргэд
2	Шинээр бүртгэгдсэн иргэдийн тоо	452	Орон гэргүй болж шинээр бүртгэгдсэн үзүүлэлт
3	Цагдаагийн байгууллагатай хамтран илрүүлэг арга хэмжээг зохион байгуулсан тоо	53	Нийслэлийн 7 дүүргийн Цагдаагийн газар хэлтсүүдтэй хамтран ажилласан
4	Өдөр тутмын үзлэгт хамруулсан /давхардсан тоо/	3937	Үйлчлүүлэгч иргэдэд өдөр тутмын үзлэг хийсэн үзүүлэлт
5	Эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлсэн	61	Энэрэл, Аддиктологийн төв, СЭМҮТ зэрэг эмнэлгүүдэд хэвтүүлэн эмчлүүлсэн
6	Бичиг баримтжуулсан	16	Иргэний үнэмлэх
7	Тэтгэвэр, тэтгэмжид хамруулсан	8	Халамжийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмжүүд
8	Ахмад настны асрамжид шилжүүлсэн	2	**
9	Зохион байгуулсан сургалтын тоо	50	Нийгмийн ажилтан, эмч, сэтгэл зүйч нарын зохион байгуулсан сургалт
10	Хөгжлийн сургалтад хамрагдсан иргэд /давхардсан тоо/	1800	**
11	Сэтгэл зүйн оношилгоонд хамруулсан	419	Архины хамаарлын түвшин тогтоох оношилгоо болон сэтгэц оношилгоо
12	Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө	303	**
13	Сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөө	469	**
15	Ажлын байранд зуучилсан	240	Тогтвортой болон түр ажлын байранд зуучлагдсан үзүүлэлт
16	Бие даасан амьдралд шилжүүлсэн	31	**

НХТЖҮЧ 3.1.1, 3.2.1 НЗДҮАХ 2.4.1 Нийгмийн хамгааллын тусгай төвийн “Сургалт хүмүүжлийн төв”-ийн барилгын ажлыг үргэлжлүүлэх

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН ӨРТГӨТГӨЛ БУЮУ “СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ЦОГЦОЛБОР ТӨВ”-ИЙН БАРИЛГЫН АЖЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

2024 оны 11 дүгээр сарын 01

Улаанбаатар хот

2020 оны 05 дугаар сарын 04-ний Улаанбаатар хотын Засаг даргын А/600 дугаар захирамж-аар БЗД, 20 дугаар хороо Майхантын аманд Нийгмийн хамгааллын тусгай төвийн өргөтгөл “Сургалт хүмүүжлийн цогцолбор төв”-ийн барилгын ажлыг эхлүүлсэн.

Барилгын нийт төсөв 5,96 тэрбум төгрөг байсан бөгөөд барилгын материалын үнийн зөрүүгээс үүдэн 2020-2024 онд Нийслэлийн санхүүжилтээр нийт 6,586 тэрбум төгрөгийн ажил хийгдэж, барилга ашиглалтад орох шатандаа үргэлжилж байна.

Сургалт хүмүүжлийн цогцолбор төвийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон ерөнхий төлөвлөлтийн зураг



БАРИЛГА БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦ (2020-2024 ОН)

2020 он 1,395 тэрбум төсөвлөгдөж барилгын иж бүрэн зураг төсөв 95 сая төгрөгөөр хийгдсэн бөгөөд тендерт шалгарсан Голдон лайт ХХК 1,2 тэрбум төгрөгөөр 2020 онд гүйцэтгэл хийсэн: Үүнд барилгын газар шороо, суурийн ажил, каркас угсралтын ажил.



2022 он Нийслэлийн төсөвт 2,1 тэрбумаар төгрөг батлагдаж гүйцэтгэл хийсэн: Үүнд: (Барилгын гадна, дотор өрлөг, гадна фасад,, дээврийн ажил хийгдэж дууссан, гүний худаг гаргасан, 3 га талбайн гаднаа хашаа барьсан)



2023 он Нийслэлийн төсөвт 200 сая төгрөг батлагдаж гүйцэтгэл хийгдсэн. Үүнд: (Гадна эрчим хүч татах ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгаад байна.)



2024 онд: Өргөтгөлийн барилгыг гүйцэтгэж дуусгахад шаардлагатай 2 тэрбум 891 сая төгрөг Нийслэлийн 2024 оны төсөвт батлагдсан бөгөөд гүйцэтгэгч Тэмээн ХХК-ны зүгээс гэрээний хугацаанд буюу 2024 онд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа тухайгаа мэдэгдсэн.

Ажлын явц

Уурын зуухны барилга, худгийн барилга, харуулын байр тус бүрийн гүйцэтгэл 90%, гадна тохижилт, зам талбайн ажлын гүйцэтгэл 95%, Сургалт хүмүүжлийн цогцолборын барилгын гүйцэтгэл 90%, бохир, цэвэр усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажил бүрэн дууссан, 2024 оны 11 дүгээр сарын 20-ноос галлагаа эхэлж барилга руу дулаан өгч дотор заслын ажлыг гүйцэтгэнэ. Барилгын ажлыг 12 сарын 20-25нд бүрэн дуусгаж комисс оруулахаар ажиллаж байна гэж гүйцэтгэгч талаас мэдэгдсэн.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн дарга, хариуцсан ажилтан нар барилгын ажлын явцтай 2024 онд 4 удаа газар нь очиж танилцаж, ашиглагч байгууллагын хувьд гүйцэтгэгч байгууллагын инженерүүдээс зөвлөмж авч мөн барилгын ажлын явцыг хурдасгах талаар санал зөвлөмж өгч ажилласан.

Барилгын ажлын явцын зураг /2024.08.01/





Барилгын ажлын явцын зураг /2024.10.15/



Барилгын ажлын явцын зураг /2024.11.06/



Барилгын нийт төсөв: **5,96 тэрбум төгрөг**

Барилгын материалын үнийн дүнгийн зөрүүгээс үүдэн гүйцэтгэлд зарцуулагдсан
нийт төсөв: **6,586 тэрбум төгрөг**



ХЯНАСАН:
АХЛАХ АРГА ЗҮЙЧ

М.МӨНХСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН АЖИЛТАН

Э.ПҮРЭВСҮРЭН